



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

□ Бүтэц, орон тоо, цалин хөлсний нэмэгдэл □
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2019 оны 276 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт, 2022 оны 107 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, мөн оны 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, мөн оны 491 дүгээр тогтоол, Соёлын өвийн үндэсний төвийн дүрмийн 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний төвийн бүтэц, орон тоог 1 дүгээр, цалин хөлсийг 2 дугаар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 дугаар, эрдмийн зэргийн нэмэгдлийг 4 дүгээр, ажилтнуудын унаа, хоолны нэмэгдлийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цалинг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдөж, холбогдох эрх зүйн баримт бичиг, дүрэм журмын дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Ч.Өнөртогтох)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Д.Нарантуяа)-д даалгасугай.


4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2022 оны Б/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИВАЛ



Г.ЭНХБАТ

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 01... дүгээр сарын 02-ны өдрийн
А/01 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Бүтцийн нэгж	Албан тушаал	Албан тушаалын ангилал	Орон тоо
1	2	3	4	5
1	Захиргаа, удирдлагын газар	Газрын дарга	ТҮ-11	1
		Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга	ТҮ-11	1
		Ерөнхий нягтлан бодогч	ТҮ-8	1
		Тооцооны нягтлан бодогч	ТҮ-7	1
		Дотоод хяналт шалгалтын ажилтан	ТҮ-7	1
		Хүний нөөцийн ажилтан	ТҮ-7	1
		Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	ТҮ-7	1
		Олон нийттэй харилцах ажилтан	ТҮ-7	1
		Мэргэжилтэн	ТҮ-7	1
		Архив-бичиг хэргийн эрхлэгч	ТҮ-5	1
		Нярав	ТҮ-4	1
		Цахилгаанчин	ТҮ-3	1
		Слесарь	ТҮ-3	2
		Жолооч	ТҮ-3	1
		Үйлчлэгч	ТҮ-1	2
	НИЙТ			17
2	Бүртгэл, мэдээллийн газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч	ТҮСУ-6	1
		Бүртгэл, мэдээллийн санч (Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан)	ТҮСУ-5	2
		Бүртгэл, мэдээллийн санч (Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан)	ТҮСУ-5	2
		Бүртгэл, мэдээллийн санч (Баримтат өв хариуцсан)	ТҮСУ-5	1
		Бүртгэл, мэдээллийн санч (Соёлын биет бус өв хариуцсан)	ТҮСУ-5	3
		Бүртгэл, мэдээллийн санч (Архивч)	ТҮСУ-5	1
		Бүртгэл, мэдээллийн санч	ТҮСУ-5	1
	НИЙТ			12
3	Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Ерөнхий технологич	ТҮСУ-6	1
		Сэргээн засварлагч	ТҮСУ-5	2
		Ариутгалын технологич (химич)	ТҮСУ-5	1
		НИЙТ		
4	Сэргээн засварлах газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Ерөнхий сэргээн засварлагч	ТҮСУ-6	1
		Сэргээн засварлагч (даавуу, зөөлөн эдлэл)	ТҮСУ-5	2
		Сэргээн засварлагч (металл эдлэл)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (монгол зураг)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (чулуун эдлэл)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (модон эдлэл)	ТҮСУ-5	1

		Сэргээн засварлагч (цаасан урлал)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (баримал)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (археологийн олдвор)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (танка)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (керамик)	ТҮСУ-5	1
		Сэргээн засварлагч (арьс шир)	ТҮСУ-5	1
		Сан хөмрөгч	ТҮСУ-5	1
		НИЙТ		15
5	Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Инженер	ТҮСУ-5	1
		Дурсгалт уран барилга, архитектурын зураг төслийн мэргэжилтэн	ТҮСУ-4	3
		НИЙТ		5
6	Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Шинжээч (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын)	ТҮСУ-5	1
		Шинжээч (Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн)	ТҮСУ-5	1
		Шинжээч (Соёлын биет бус өвийн)	ТҮСУ-5	1
		НИЙТ		4
7	Мэдээллийн технологийн газар	Газрын дарга	ТҮСУ-6	1
		Программист	ТҮСУ-5	2
		Компьютер графикч	ТҮСУ-4	2
		Инженер (Газар зүйн мэдээллийн зайнаас тандан судлах)	ТҮСУ-4	1
		НИЙТ		6
НИЙТ ОРОН ТОО				64